

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**

2023.06.28

Улаанбаатар хот

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага Хэрэгжүүлэх хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг), эх үүсвэр	Суурь түвшин	2023 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц, үр дүн, хэрэгжилтийн хувь
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	
1	2	3	4	5	6	7	8	9
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>								
<b>3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.</b>								
3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЗГ  2020-2024	1,628,400.0  Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт (30% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 70% гадаад/дотоод хөрөнгө	0%	Үйлдвэрийн барилгын ажил үргэлжлэх, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг хийнэ. 80%	488,520.0	13,488.9	<b>ТӨБЗГ - ТӨҮЗХ</b>  Үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэрийн төслийг БНХАУ-ын China ENFI Engineering (ENFI) компанитай хамтран хэрэгжүүлж байна. Үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэр барьж, туршилт хийх ажлыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуоун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна.  2023.05.21-28-ны өдрүүдэд "ЭҮ" ТӨҮГ-ын 3 ажилтан туршилтын үйлдвэрлэлийн барилгын ажлын явцтай газар дээр нь танилцсан. Томилолтын тайланд тусгагдсанаар: Туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн

			оруулалт, зээл)				<p>угсралтын ажил 100% буюу нийт угсралт суурилуулалтын гүйцэтгэл 60%-тай байна. Барилгын ажил 70%-ийн гүйцэтгэлтэй, үлдсэн суурилуулалтыг 2023.07.15-ны дотор дуусгаж, туршилт тохируулгын ажлыг эхлүүлнэ, 2023.08.01-ээс үйлдвэрлэлийн туршилтын ажлыг эхлүүлэхэд бэлэн болох ба үйлдвэрлэлийн туршилтыг 2 сарын хугацаанд явуулна. Гэрээг сунгах ажил хийгдэж байна.</p> <p>ЗБХБҮ-ийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах ажлын тендерийг зарлахаар бэлтгэж байна. Үнэлгээний хороо байгуулагдсан. Үйлдвэрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг ажлын төсөвт өртөгт шаардлагатай өөрчлөлтийг оруулан тусгаж, "Эрдэнэс Монгол" группийн ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p>-ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхээр шалгарсан "Хатан далай" ХХК-тай 2023.02.08-ны өдөр гэрээ байгуулсан. Тус гүйцэтгэгчээс ирүүлсэн материалд үндэслэн үнэлгээний ерөнхий дүгнэлтийг БОАЖЯ-аас гаргасан байна. Явц 30%.</p> <p>-ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэхээр тендер зарласан.</p> <p>- "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерт шалгарсан "Эс Ай Си Эй" ХХК-тай 2022.11.28-ны өдрийн 06/002-22 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Эхний тайланг ажлын хэсэг хүлээж авсан. 2023.05.04-ний өдөр</p>
--	--	--	--------------------	--	--	--	--

								дундын тайлангийн танилцуулга хийгдсэн. Явц 45%. <b>Хэрэгжилтийн хувь: 50%</b>
<b>3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.</b>								
3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.	1.Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.	БХБЯ, ТӨБЗГ 2020-2024	-	-	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.	-	-	<b>ТӨБЗГ – ТӨУЗХ</b>  Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК болон “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 13 дугаар тэмдэглэл гаргасан.  “Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар болсон байх боловч өнөөдрийг хүртэл ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.  Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас дээр дурдсан ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэх, зохих шийдвэр гаргах

								<p>боломжтой. Нийслэлийн ИТХ-ын шийдвэр гараагүй тул удааширч байна.</p> <p>“Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац” байгуулахтай холбоотой асуудлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яам, “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн зүгээс “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, өөрчлөх, өргөтгөх чиглэлээр санал боловсруулан Засгийн газрын шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 70%</b></p>
--	--	--	--	--	--	--	--	---

**ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**4.1. “Цахим Монгол”- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.**

4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбоно.	ТӨБЗГ 2020-2024	7,360.0	Иргэн, хуулийн этгээдэд Төрийн үйлчилгээний e-mongolia.mn системээр дамжуулан 181 үйлчилгээг хүргэж байна.	Хоёр шатлалт 80 үйлчилгээ шинээр оруулсан байна.	1,840.0	-	<p><b>Тайлбар:</b></p> <p>Энэ арга хэмжээг ТӨБЗГ-аас санал өгч тусгаагүй, алдаа үүссэн байх тул тус байгууллагаас хэрэгжилтийг тайлагнах боломжгүй.</p> <p>Манай байгууллагын эрхлэн хариуцах ажил биш тул үнэлгээг 100 % гэж авч нийт үнэлгээнд тусгасан болно.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 100%</b></p>
	5.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн	ТӨБЗГ 2021-2024	1,200.0  Улсын төсөв	Программын болон техник хангамжийг сайжруу-	Мэдээллийн санг бий болгох ажлыг шийдвэр-	300.0	-	<p><b>ТӨБЗГ – ТӨБАХ, МТА, ЗУХ</b></p> <p>Уг мэдээллийн системийг боловсронгуй болгоход шаардагдах нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөв Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга</p>

	<p>системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.</p>			<p>лах шаардлагатай.</p>	<p>лэсэн байна.</p>			<p>хэмжээний жагсаалтад тусгагдан зарим тендер зарлагдсан байсан нь 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлтэй холбоотой цуцлагдсан.</p> <p>ТӨБЗГ-аас байгууллагын 2023 оны төсвийн урсгал зардлаар уг зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорьж, шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийн зардлыг төсвийн төсөлд тусгаж, саналаа Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн боловч батлагдаагүй. Иймд, 2022 онд зохион байгуулсан төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод хөгжүүлэн ашигласан эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн системийг тодорхой түвшинд өргөжүүлж, зарим мэдээллийг нэмэх, боловсруулах, тухайлбал, хөрөнгийн орлого, зарлага, шилжилт хөдөлгөөн, их засвар, капиталжуулалт, данснаас хасах зэрэг үйлдлийг нэмж оруулан ашиглаж байна.</p> <p>Мөн уг төсөл, арга хэмжээг “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгахаар холбогдох журам, аргачлалын дагуу санал, үндэслэл, тайлбарыг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А-1/96 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Уг хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах хүрээнд ЭЗХЯ-аас уулзалт хийх, тодруулга, нэмэлт мэдээлэл авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах үеэр санал өгсөн төсөл, арга хэмжээнүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, уг асуудлыг зайлшгүй хөгжлийн төлөвлөлтөд тусгах шаардлага, үндэслэл бүхий тайлбар, мэдээллийг ТӨБЗГ-аас гарган өгсөн болно. Ингэснээр, МУИХ-ын 2023 оны 39 дүгээр</p>
--	--	--	--	--------------------------	---------------------	--	--	--

								<p>тогтоолоор батлагдсан “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тус асуудал тусгагдан батлагдсан болно. Уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн санхүүжилтийг төсвийн төслийг боловсруулах, батлах хүрээнд шийдвэрлүүлэхээр холбогдох саналыг боловсруулж байна.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 50%</b></p>
<p><b>4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.</b></p>								
<p>4.2.4.Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.</p>	<p>1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана.</p>	<p>ТӨБЗГ 2021-2024</p>	<p>-</p>	<p>Эрх зүйн орчин сул, бүтэц, орон тоо, төсөв хангалтгүй.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийг нэгдсэн удирдлагаар хангана.</p>	<p>-</p>	<p>-</p>	<p><b>ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨУЗХ</b></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газраас, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус тус бусад холбогдох хуулийн төслийн хамт 2022 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангах зохицуулалтыг тусгасан байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар уг хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх анхны хэлэлцүүлэгт бэлтгэх, Эдийн засгийн Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Уг ажлын хэсгээс өгсөн үүрэг, чиглэлийн дагуу холбогдох материал, судалгаа,</p>

							<p>дүгнэлтийг боловсруулах, холбогдох мэдээллээр хангах чиглэлээр ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын шийдвэрээр 2022 онд стратегийн томоохон ач холбогдол бүхий уул, уурхайн салбарын “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой дулааны станц” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-д нэгтгэн нэгдлийн хэмжээнд ажиллуулах шийдвэрийг Засгийн газраас гаргасан. “Эрдэнэс Монгол” нэгдлийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байхаар тогтоосон.</p> <p>“Эрдэнэс Монгол” нэгдэлд хамааруулснаас бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтцийг оновчтой болгох, үр ашгийг дээшлүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэгтгэх, нийлүүлэн зохион байгуулах арга хэмжээ авч, одоогийн байгаа 80 хуулийн этгээдийг 35 болгох саналыг боловсруулан шийдвэрийн төслийн хамт ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-1/566 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор Автозам засвар арчлалтын үйл ажиллагаа явуулж буй 20 ТӨХК-ийг нэгтгэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийг байгуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Түүнчлэн, эрчим хүчний салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага менежментийг боловсронгуй болгох асуудлыг судлан санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар холбогдох материалыг бэлтгэн ЗГХЭГ-т хүргүүлээд байна.</p>
--	--	--	--	--	--	--	---

								Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төрийн өмчийн нэгдмэл удирдлагын тогтолцоо бий болох, төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, улсын томоохон бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах зэрэг бусад олон давуу талууд бий болно гэж үзсэн. <b>Хэрэгжилтийн хувь: 90%</b>
2.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.	ТӨБЗГ 2020-2024	196.0 Улсын төсөв	19 хуулийн этгээд	25 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн байна.	66.0	10.4	<b>ТӨБЗГ – ТӨХШХ</b> ТӨБЗГ-аас төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа болон эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөнд төрийн өмчит 7 үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 18 компани, төрийн өмчит төсөвт 10 байгууллага, нийт 35 хуулийн этгээдэд хяналт, шалгалт хэрэгжүүлэхээр тусгасан. Төлөвлөгөөний дагуу ТӨБЗГ-ын даргын баталсан удирдамжаар 2023 оны эхний хагас жилийн байдлаар 9 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалтыг хэрэгжүүлээд байна. Үүнд: 1. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ; 2. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ; 3. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ; 4. “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ; 5. “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК; 6. “Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК; 7. “Багануурын дулааны станц” ТӨХК; 8. “Налайхын дулааны станц” ТӨХК; 9. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК.	



								<p>Засгийн газрын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх, бусад тодорхой шалтгааны улмаас 2022 оны сүүлийн хагас жилд төрийн өмчит 27 хуулийн этгээдэд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын тайланг хойшлуулж, 2023 оны эхний хагас жилд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан. Эдгээр хуулийн этгээдэд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн нийт 11,567.38 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын газрын тогтоолоор баталгаажуулсан. Шалгалтын тайланг тогтоолын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.</p> <p>Засгийн газрын 2022 оны “Тавантолгой ХК-ийн талаар авах арга хэмжээний тухай” 450 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн сайдын 2023 оны СХЭУГ/01 дугаартай удирдамжийн дагуу “Тавантолгой” ХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажилласан. Хяналт шалгалтын дүнгээр тус компанид мөрдөж буй хууль, тогтоомжийг зөрчсөн, төрийн өмчийн асуудалтай холбоотой 170 гаруй тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд холбогдох тайлан, дүгнэлтийг ажлын хэсгийн нэгдсэн дүн, тайланд тусгуулав.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 70%</b></p>
3.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд	ТӨБЗГ 2020-2024	75.0	7 хуулийн этгээд	10 төсөвт байгууллагад шалгалт хийсэн байна.	25.0	-	<p><b>ТӨБЗГ – ТӨХШХ</b></p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төсөвт 2 хуулийн этгээдийн төрийн өмчийн захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдалд системийн</p>	

	хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ.							<p>хяналт шалгалт хийж, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан. Хяналт шалгалтын дүнгээр нийт 359.35 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын тогтоолоор баталгаажуулав.</p> <p>Илэрсэн зөрчил, дутагдал, холбогдох шийдвэр:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Боловсрол, шинжлэх ухааны яам - 343.85 сая төгрөгийн зөрчил, дутагдал, ТӨБЗГ-ын 2023 оны 190 дүгээр тогтоолоор;</li> <li>2. Эрчим хүчний зохицуулах хороо - 15.5 сая төгрөгийн зөрчил, дутагдал, ТӨБЗГ-ын 2023 оны 275 дугаар тогтоолоор.</li> </ol> <p>Хяналт шалгалтын тайланг тогтоолын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж, зөрчил, дутагдлыг арилгах, тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авсан.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 50%</b></p>
<b>4.4. Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.</b>								
4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн	2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.	ТӨБЗГ 2021-2023	-	Зарим дүрэм, журам батлах эрх хуулиар олгогдоогүй.	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын асуудлаар 3 журмын төслийг баталж, мөрдүүлсэн байна.	-	-	<p><b>ТӨБЗГ – ХЭЗХ</b></p> <p>Холбогдох хуулийн шинэчлэл батлагдаагүй байгаа боловч төрийн өмчийн харилцааны зарим асуудлыг бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд өөрчлөн шинэчлэх, боловсронгуй болгож, нийцүүлэх ажлууд хийгдэж байна. Тухайлбал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор өгсөн үүргийн дагуу “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын төслийг боловсруулж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг</p>

<p>засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.</p>								<p>эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлуулсан. Уг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд ТӨБЗГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А-1/194 дүгээр албан бичгээр төрийн өмчит бүх шатны байгууллагад чиглэл хүргүүлэв. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой ТӨБЗГ-ын 2022 оны 184 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, холбогдох гэрээний загварыг шинэчлэн баталж мөрдүүлсэн.</p> <p>“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын төсөл, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын төсөл, “Төрийн өмчит хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ын төсөл болон холбогдох танилцуулгыг боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/209 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар уг журмын төслүүдийг хэлэлцэж, Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолоор тус тус баталсан. Уг журмуудыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 100%</b></p>
	3.Төрийн өмчит болон төрийн	ТӨБЗГ 2021-2024	-	Компанийн засагла-	Компанийн засаг-	-	-	<b>ТӨБЗГ – ТӨУЗХ</b>

	<p>өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ.</p>			<p>лын дундаж үнэлгээ - 53.9 хувь</p>	<p>лалын дундаж үнэлгээг 75.0 хувьд хүргэсэн байна.</p>			<p>Төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор 3 хэсэгт хуваан авч үзэн санал боловсруулж, ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэр, саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Саналыг судлан шийдвэрлэх хүрээнд Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор автозам засвар арчлалтын үйл ажиллагаа явуулж буй 20 ТӨХК-ийг нэгтгэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийг байгуулахаар шийдвэрлэсэн. Түүнчлэн, эрчим хүчний салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага менежментийг боловсронгуй болгохоор хүргүүлсэн саналыг Засгийн газрын түвшинд судалж байна.</p> <p>Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам” шинэчлэгдэн батлагдсан бөгөөд уг журмаар төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн чиг үүргийг тодорхой болгон шийдвэрлэсэн.</p> <p>Мөн Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 85 дугаар тогтоолоор “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>ТӨБЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал”-ыг</p>
--	--	--	--	---------------------------------------	---	--	--	--

								<p>баталсан. Уг аргачлалыг мөрдөн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, энэ чиглэлээр олон улсын туршлага судлах, зарим улс орон, олон улсын байгууллагын төлөөлөлтэй уулзаж, цаашид тодорхой асуудлаар хамтран ажиллах талаар санал солилцох ажлууд хийгдлээ. Тухайлбал, Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2023 оны 04 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Франц улсын Парис хотод зохион байгуулагдсан 40 дэх удаагийн OECD ба төрийн өмч, хувьчлалын асуудлаарх хуралд УИХ, Засгийн газар болон ТӨБЗГ-ын төлөөлөл оролцсон. Мөн Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Монгол Улсын эрчим хүчний засаглал” хөтөлбөрийн хүрээнд “Вителли Ассошиэйтс” хуулийн фирмийн төлөөлөл, Сингапур Улсын Засгийн газрын агентлаг-Төрийн өмчит компанийн хамтын ажиллагааны газрын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, санал солилцов. БНХАУ-ын ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, яриа хэлцэл хийх зэргээр ажиллав.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 70%</b></p>
4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг	ТӨБЗГ 2022-2024	-	Хуулийн этгээдэд урт болон дунд хугацааны бизнес /хөгж-	Тухайн жилийн зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг	-	-	<p><b>ТӨБЗГ – ТӨУЗХ</b></p> <p>ТӨБЗГ-аас Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй 43 хуулийн этгээдийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.</p>	

	<p>нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.</p>			<p>лийн/ төлөвлөгөө байхгүй.</p>	<p>баталсан байна.</p>		<p>Түүнчлэн, 41 хуулийн этгээдийн болон Эрчим хүчний салбарын компаниудын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг тус тусын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Дээрх ажлын дүн болон аудитаар баталгаажсан 2022 оны санхүүгийн тайлангийн дүнгийн нэгтгэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 хуулийн этгээд нийт дүнгээр 14,553,979.9 сая төгрөгийн орлого олж, 11,561,950.2 сая төгрөгийн зардал гаргаж, 2,055,798.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлын хүрээнд зарим хуулийн этгээдийг татан буулгах, нэгтгэх, хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй худалдаж, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үе шаттай хэрэгжүүлж байна. “Төрийн банк” ТӨХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн IPO амжилттай хэрэгжиж байна. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн IPO-г зарлахад бэлэн болсон ба “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн IPO хийх бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Төрийн өмчит авто зам засвар, арчлалтын 20 компанийн бүтцийг оновчтой болгох, засаглал, үр ашгийг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах зорилгоор эдгээр компанийг нэгтгэж, өөрчлөн зохион байгуулахаар санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг саналыг</p>
--	---	--	--	----------------------------------	------------------------	--	--

								Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 2023 оны 220 дугаар тогтоолоор шийдвэрлээд байна. <b>Хэрэгжилтийн хувь: 90%</b>
5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.	ТӨБЗГ 2021-2024	425.0 Улсын төсөв	2016 оны улсын нэгдсэн тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн.	900 хуулийн этгээдтэй байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн байна.	25.0	13.4	<b>ТӨБЗГ – ТӨБАХ</b> Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг 2022 онд зохион байгуулж, уг үзлэг тооллогод нийт 6614 хуулийн этгээд хамрагдсанаас төрийн өмчит 1273, орон нутгийн өмчит 5341 хуулийн этгээдийн нийт 91.8 их наяд төгрөгийн өртөг бүхий эд хөрөнгө тоологдсон байна. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогын дүнг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Уг танилцуулгатай холбоотойгоор Засгийн газрын “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 481 дүгээр тогтоол батлагдсан. Тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТӨБЗГ-ын даргын 2023 оны А/23 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүн болон “Төрийн өмчийг эзэмшүүлэх 2021 оны гэрээ”-ий биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, албан даалгаврыг нийт төрийн өмчит хуулийн этгээдэд ТӨБЗГ-ын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А-1/533 дугаар албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулав.  Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Албан томилолтоор ажиллуулах тухай” А/42 дугаар тушаалаар байгуулагдсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх 2022 оны гэрээ”-г дүгнэх, татан буугдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий	

							<p>газрын эзэмшиж байсан хөрөнгийн асуудалтай холбоотой Засгийн газрын 2023 оны “Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд холбогдох байгууллагад үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагын асуудлыг судлан, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд 21 аймагт ажиллаж байна.</p> <p>“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2022 оны үнэлгээ, дүн, дүгнэлтийг графикт хугацааны дагуу 2023 оны сүүлийн хагас жилд нэгтгэн боловсруулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулна.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь: 70%.</b></p>
--	--	--	--	--	--	--	---

### ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

ЗГҮАХХАХТ-нд 2 бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хангахад чиглэсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 онд хариуцан хэрэгжүүлэх нийт 11 арга хэмжээ тусгагдсан. Эдгээрээс 1 арга хэмжээ нь тус байгууллагын хуулиар олгосон чиг үүрэгт шууд хамааралгүй тул уг арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх боломжгүй байна. Байгууллагын үнэлгээнд нөлөөлөхгүй байх үүднээс холбогдох тайлбарыг тухайн арга хэмжээний хэрэгжилтийн байдалд тэмдэглэж, “100 хувь” гэж үнэлэн нийт дүнд тусгасан болно.

#### **Үнэлгээний дүнгийн товч танилцуулга (2023 оны эхний хагас жил):**

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – 11; Үүнээс:

- 100 %-ийн хэрэгжилттэй - 2 арга хэмжээ;
- 90 %-ийн хэрэгжилттэй - 2 арга хэмжээ;
- 70 %-ийн хэрэгжилттэй - 4 арга хэмжээ;
- 50 %-ийн хэрэгжилттэй – 3 арга хэмжээ;



- 30 %-ийн хэрэгжилттэй - 0 арга хэмжээ;
- 0 % - 0 арга хэмжээ;
- Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа – 0 арга хэмжээ.

Хэрэгжилтийн дундаж үнэлгээ – **73.64% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”** байна.

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ